



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 64

Алтай

**Хөрөнгө шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2002 оны 55 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус аймгийн Ардын дуу бүжгийн “Алтай” чуулгын хуучин барилгыг Боловсрол, соёл урлагын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Шилжүүлсэн эд хөрөнгийг комисс томилон хүлээлцэж, холбогдох байгууллагуудын хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг зохих хууль, журмын дагуу хийн хяналт тавьж, эргэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга / С.Гансэлэм/, Орон нутгийн өмчийн газарт даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ



Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын  
Тэргүүлэгчдийн 2016 оны 10 дүгээр сарын 27 өдрийн  
64 д тогтоолын хавсралт

ШИЛЖҮҮЛЭХ ӨМЧ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/Д	Эд хөрөнгийн нэр	Байгууллагын нэр		Хөрөнгийн үнийн дүн /мянган төгрөг/
		Шилжүүлэх	Шилжүүлэн авах	
1.	АБДАЧ-ийн хуучин барилга	Ардын дуу бүжгийн Алтай чуулга	Боловсрол соёл урлагийн газар	442772,0